



## УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2026/001/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаангом сум  
2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: [BatsuuriM@audit.gov.mn](mailto:BatsuuriM@audit.gov.mn)

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: [Bat-Amgalanm@audit.gov.mn](mailto:Bat-Amgalanm@audit.gov.mn)

Аудитор: Т.Ариунсайхан

Утас: 70453799, Цахим хаяг: [Ariunsaikhant@audit.gov.mn](mailto:Ariunsaikhant@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<b>АГУУЛГА</b>	
<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b>	<b>4</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b>	<b>6</b>
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b>	<b>11</b>
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.6.1 Төсвийн төлөвлөлт	13
3.6.2 Төсвийн гүйцэтгэл	13
3.6.3 Нэмэлт төсөв	13
3.6.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	14
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b>	<b>14</b>
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	15
<b>4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</b>	<b>15</b>
4.5.1 Завсрын аудитын талаар	15
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	15
<b>4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал</b>	<b>15</b>
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b>	<b>15</b>
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b>	<b>15</b>

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

АЙМГИЙН НИЙГМИЙН  
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Ц.БАТСҮРЭН ТАНАА

2026, 03, 13 № УВА-2026/001/НА-СТА-ЗГТС  
танай -ны № -т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайлан болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

8575050208

## **Бусад асуудлын хэсэг**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>1.1 ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>9,744,785,813.26</b>	<b>10,218,149,392.62</b>
<b>31</b>	<b>1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>7,745,776,278.68</b>	<b>7,741,770,014.13</b>
<b>31200</b>	<b>1.1.1.02 Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>7,745,776,278.68</b>	<b>7,741,770,014.13</b>
31210	1.1.1.02.01 Төгрөг	7,745,776,278.68	7,741,770,014.13
31213	1.1.1.02.01.03 Арилжааны банк дахь харилцах	7,745,776,278.68	7,741,770,014.13
<b>33</b>	<b>1.1.3 АВЛАГА</b>	<b>1,999,009,534.58</b>	<b>2,476,379,378.49</b>
33300	1.1.3.03 Татаас, санхүүжилтийн авлага	895,359,550.08	894,971,906.08
33402	1.1.3.06 Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	936,726,048.01	1,487,857,979.93
33500	1.1.3.07 Бусад авлага	166,923,936.49	93,549,492.48
33510	1.1.3.07.01 Байгууллагаас авах авлага	16,542,559.02	10,961,045.85
33520	1.1.3.07.02 Хувь хүмүүсээс авах авлага	150,381,377.47	82,588,446.63
<b>3</b>	<b>1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>	<b>9,744,785,813.26</b>	<b>10,218,149,392.62</b>
<b>4</b>	<b>2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,804,140,510.15</b>	<b>2,882,392,259.6</b>
<b>41</b>	<b>2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,804,140,510.15</b>	<b>2,882,392,259.6</b>
41300	2.1.1.03 Өглөг	305,715,692	403,559,075.69
41360	2.1.1.03.06 Бусад өглөг	305,715,692	403,559,075.69
41361	2.1.1.03.06.01 Байгууллагад төлөх өглөг	32,730,469	27,210,105
41362	2.1.1.03.06.02 Хувь хүмүүст төлөх өглөг	260,058,031.95	364,212,971.24
41366	2.1.1.03.06.06 Дансны өглөг /ТӨҮГ/	12,927,191.05	12,135,999.45
41400	2.1.1.04 Урьдчилж орсон орлого	1,498,424,818.15	2,478,833,183.91
41410	2.1.1.04.01 Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	1,498,424,818.15	2,478,833,183.91
<b>5</b>	<b>2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>7,940,645,303.11</b>	<b>7,335,757,133.02</b>
51	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	7,940,645,303.11	7,335,757,133.02
51200	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	7,940,645,303.11	7,335,757,133.02
51210	2.2.1.08.01 Өмнөх үеийн үр дүн	10,806,569,216.48	7,875,362,247.94
51220	2.2.1.08.02 Тайлант үеийн үр дүн	-2,865,923,913.37	-539,605,114.92
<b>6</b>	<b>2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>	<b>9,744,785,813.26</b>	<b>10,218,149,392.62</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>164,740,496,338.35</b>	<b>188,867,747,709.1</b>
<b>11</b>	<b>1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>45,880,135,543.05</b>	<b>54,202,499,560.64</b>

112	1.1.1.03.2 Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	45,880,135,543.05	54,202,499,560.64
1122	1.1.1.03.2.01 Тэтгэврийн даатгалын шимтгэл	38,717,147,874.02	45,659,459,284.47
112001	1.1.1.03.2.01.03 Бусад тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого	38,717,147,874.02	45,659,459,284.47
112002	1.1.1.03.2.02 Тэтгэмжийн даатгалын шимтгэлийн орлого	4,026,908,477.1	4,762,422,722.39
112003	1.1.1.03.2.03 ҮОМШ өвчний даатгалын шимтгэлийн орлого	1,822,830,867.04	2,202,607,628.21
112004	1.1.1.03.2.04 Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлого	1,313,248,324.89	1,578,009,925.57
<b>12</b>	<b>1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>170,741,765.82</b>	<b>134,665,248,148.46</b>
120	1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	170,741,765.82	310,096,498.46
1201	1.1.1.04.1.02 Хүүгийн орлого	53,657,932.75	67,578,696.62
120002	1.1.1.04.1.02.02 Бусад хүүгийн орлого	53,657,932.75	67,578,696.62
120003	1.1.1.04.1.03 Торгуулийн орлого	0.0	854,850
120009	1.1.1.04.1.09 Бусад орлого	117,083,833.07	241,662,951.84
122	1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	134,355,151,650
1221	1.1.1.04.3.01 Хандив тусламж /дотоод/	0.0	134,355,151,650
12215	1.1.1.04.3.01.05 Төсөв хоорондын хандив, тусламж	0.0	21,583,653,356
122152	1.1.1.04.3.01.05.2 НДС-д УТ-с олгох татаасын орлого \УТ-НДС\	0.0	21,583,653,356
122004	1.1.1.04.3.01.07 НДС-ын санхүүжилтийн шилжүүлгийн орлого\	0.0	112,771,498,294
<b>13</b>	<b>1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>118,689,619,029.48</b>	<b>0.0</b>
1310	1.1.1.05.1 Улсын төвлөрсөн төсвөөс	17,930,502,156.48	0.0
131001	1.1.1.05.1.01 Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	17,930,502,156.48	0.0
1330	1.1.1.05.4 Төсвийн захирагчдаас	100,759,116,873	0.0
133002	1.1.1.05.4.02 Төвлөрүүлэх шилжүүлэг	100,759,116,873	0.0
<b>II</b>	<b>1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>167,606,420,251.72</b>	<b>189,407,352,824.02</b>
<b>21</b>	<b>1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>167,606,420,251.72</b>	<b>189,407,352,824.02</b>
<b>210</b>	<b>1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>14,318,540</b>	<b>14,102,359</b>
2108	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,318,540	14,102,359
210801	1.1.2.01.1.08.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,358,200	5,368,589
210808	1.1.2.01.1.08.08 Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	7,960,340	8,733,770
<b>213</b>	<b>1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>167,592,101,711.72</b>	<b>189,393,250,465.02</b>
2131	1.1.2.01.4.01 Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.0	52,657,284,099.03

21311	1.1.2.01.4.01.01 Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.0	52,657,284,099.03
213104	1.1.2.01.4.01.01.5 НДС-н орлогын төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	0.0	52,657,284,099.03
2132	1.1.2.01.4.02 Бусад урсгал шилжүүлэг	120,622,384,080.92	136,735,966,365.99
213202	1.1.2.01.4.02.01 Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	120,622,384,080.92	136,735,966,365.99
2135	1.1.2.01.4.05 Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	46,969,717,630.8	0.0
213503	1.1.2.01.4.05.02 Төвлөрүүлэх шилжүүлэг	46,969,717,630.8	0.0
III	<b>1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-2,865,923,913.37</b>	<b>-539,605,114.92</b>
VI	<b>1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)</b>	<b>-2,865,923,913.37</b>	<b>-539,605,114.92</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>174,477,580,523.31</b>	<b>199,601,938,615.97</b>
<b>11</b>	<b>1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>55,853,020,484.71</b>	<b>54,632,213,491.72</b>
112	1.1.1.1.03.2 Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	55,853,020,484.71	54,632,213,491.72
1122	1.1.1.1.03.2.01 Тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого	40,112,166,140.55	46,140,149,827.63
112001	1.1.1.1.03.2.01.03 Бусад тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого	40,112,166,140.55	46,140,149,827.63
112002	1.1.1.1.03.2.02 Тэтгэмжийн даатгалын шимтгэлийн орлого	4,057,095,639.77	4,745,403,939.94
112003	1.1.1.1.03.2.03 ҮОМШ өвчний даатгалын шимтгэлийн орлого	1,936,136,795.17	2,182,748,896.54
112004	1.1.1.1.03.2.04 Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлого	1,313,074,249.64	1,563,910,827.61
1121	1.1.1.1.03.2.05 Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого	8,434,547,659.58	0.0
112005	1.1.1.1.03.2.05.05 Бусад эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого	8,434,547,659.58	0.0
<b>12</b>	<b>1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>169,618,265.6</b>	<b>144,969,725,124.25</b>
120	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	169,618,265.6	10,614,185,830.25
1201	1.1.1.1.04.1.02 Хүүгийн орлого	53,884,887.02	67,582,640.54
120002	1.1.1.1.04.1.02.02 Бусад хүүгийн орлого	53,884,887.02	67,582,640.54
120009	1.1.1.1.04.1.09 Бусад орлого	115,733,378.58	10,546,603,189.71
122	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	134,355,539,294
1221	1.1.1.1.04.3.01 Хандив тусламж /дотоод/	0.0	134,355,539,294
12215	1.1.1.1.04.3.01.05 Төсөв хоорондын хандив, тусламж	0.0	21,584,041,000

122152	1.1.1.1.04.3.01.05.2 НДС-д УТ-с олгох татаасын орлого \УТ-НДС\	0.0	21,584,041,000
122004	1.1.1.1.04.3.01.07 НДС-ын санхүүжилтийн шилжүүлгийн орлого\	0.0	112,771,498,294
<b>13</b>	<b>1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>118,454,941,773</b>	<b>0.0</b>
1310	1.1.1.1.05.1 Улсын төвлөрсөн төсвөөс	17,695,824,900	0.0
131001	1.1.1.1.05.1.01 Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	17,695,824,900	0.0
1330	1.1.1.1.05.4 Төсвийн захирагчдаас	100,759,116,873	0.0
133002	1.1.1.1.05.4.02 Төвлөрүүлэх шилжүүлэг	100,759,116,873	0.0
<b>II</b>	<b>1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>176,204,136,131.49</b>	<b>199,605,944,880.52</b>
<b>21</b>	<b>1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>176,204,136,131.49</b>	<b>199,605,944,880.52</b>
<b>210</b>	<b>1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>123,130,977.61</b>	<b>31,499,769.6</b>
2108	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,318,540	14,102,359
210801	1.1.1.2.01.1.08.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,358,200	5,368,589
210808	1.1.1.2.01.1.08.08 Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	7,960,340	8,733,770
2109	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	108,812,437.61	17,397,410.6
210901	1.1.1.2.01.1.09.01 Бараа үйлчилгээний бусад зардал	108,812,437.61	17,397,410.6
<b>213</b>	<b>1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>176,081,005,153.88</b>	<b>199,574,445,110.92</b>
2131	1.1.1.2.01.4.01 Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.0	63,025,729,098.91
21311	1.1.1.2.01.4.01.01 Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.0	63,025,729,098.91
213104	1.1.1.2.01.4.01.01.5 НДС-ын орлогын төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	0.0	63,025,729,098.91
2132	1.1.1.2.01.4.02 Бусад урсгал шилжүүлэг	120,431,149,863.49	136,548,716,012.01
213202	1.1.1.2.01.4.02.01 Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	120,431,149,863.49	136,548,716,012.01
2135	1.1.1.2.01.4.05 Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	55,649,855,290.39	0.0
213503	1.1.1.2.01.4.05.02 Төвлөрүүлэх шилжүүлэг	55,649,855,290.39	0.0
<b>III</b>	<b>1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>-1,726,555,608.18</b>	<b>-4,006,264.55</b>
<b>VIII</b>	<b>1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>-1,726,555,608.18</b>	<b>-4,006,264.55</b>
<b>101</b>	<b>1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>9,472,331,886.86</b>	<b>7,745,776,278.68</b>
<b>20</b>	<b>1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>7,745,776,278.68</b>	<b>7,741,770,014.13</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Дансны код	Дансны нэр, төрөл	1.1 Засгийн газрын оруулсан капитал	1.2 Дахин үнэлгээний нөөц	1.3 Хуримтлагдсан үр дүн	1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.0	0.0	10,962,175,601.84	10,962,175,601.84
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	-155,606,385.36	-155,606,385.36
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.0	0.0	10,806,569,216.48	10,806,569,216.48
9	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	-2,865,923,913.37	-2,865,923,913.37
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.0	0.0	7,940,645,303.11	7,940,645,303.11
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.0	0.0	7,940,645,303.11	7,940,645,303.11
12	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	-65,283,055.17	-65,283,055.17
13	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.0	0.0	7,875,362,247.94	7,875,362,247.94
19	1.7 Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	-539,605,114.92	-539,605,114.92
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.0	0.0	7,335,757,133.02	7,335,757,133.02

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	79,148,825,000	76,486,171,213.95
11	3.1.01.1.1 Татварын орлого	57,564,784,000	54,902,130,213.95
112	3.1.01.1.1.2 Нийгмийн даатгалын орлого	57,564,784,000	54,902,130,213.95
112001	3.1.01.1.1.2.1 Тэтгэврийн даатгалын шимтгэл	50,058,024,100	46,354,703,236
112002	3.1.01.1.1.2.2 Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4,181,520,800	4,757,756,326.66
112003	3.1.01.1.1.2.3 ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,856,262,700	2,183,248,815.39
112004	3.1.01.1.1.2.4 Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,468,976,400	1,606,421,835.9
12	3.1.01.1.2 Татварын бус орлого	21,584,041,000	21,584,041,000
122	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	21,584,041,000	21,584,041,000
122001	3.1.01.1.2.3.1 Хандив тусламж /дотоод/	21,584,041,000	21,584,041,000
II	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	137,072,423,100	136,562,818,371.01
21	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	137,072,423,100	136,562,818,371.01
210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,933,100	14,102,359

2108	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,933,100	14,102,359
210801	3.1.01.2.1.1.8.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,199,700	5,368,589
210808	3.1.01.2.1.1.8.08 Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	23,733,400	8,733,770
<b>213</b>	<b>3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>137,041,490,000</b>	<b>136,548,716,012.01</b>
2132	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	137,041,490,000	136,548,716,012.01
213202	3.1.01.2.1.4.2.01 Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	137,041,490,000	136,548,716,012.01
<b>8</b>	<b>3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>-57,923,598,100</b>	<b>-60,076,647,157.06</b>
<b>9</b>	<b>3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>57,923,598,100</b>	<b>60,076,647,157.06</b>
7	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	57,923,598,100	60,076,647,157.06
4	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	7,745,776,278.68
5	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	-52,330,870,878.38

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийгмийн даатгалын сан нь даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх, Нийгмийн даатгалын байгууллага нь өсөн дэвших эрмэлзэлтэй мэргэшсэн, чадварлаг, ёс зүйтэй хүний нөөцөд түшиглэн үйл ажиллагаагаа цаг үргэлжид сайжруулан, түншлэл хамтын ажиллагааг дэмжин, харилцан үр ашигтай хамтран ажиллаж, сайн засаглалыг хэрэгжүүлэн хэрэгцээ шаардлагад нийцсэн чанартай үйлчилгээг ДААТГУУЛАГЧДАД хүргэх зорилготой юм.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Нийгмийн даатгалын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон журмыг баримтална.

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Нийгмийн даатгалын багц хуульд - 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр;
- ✓ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон;
- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам";
- ✓ Төсвийн тухай хуульд - 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, 07 дугаар сарын 09-ний өдөр.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Увс аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 473,363.6 мянган төгрөгөөр буюу 4.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	7,745,776.28	7,741,770.01	(4,006.26)
Авлага	1,999,009.53	2,476,379.38	477,369.84
<b>Нийт хөрөнгө</b>	<b>9,744,785.81</b>	<b>10,218,149.39</b>	<b>473,363.58</b>
Өр төлбөр	305,715.69	403,559.07	97,843.38
Урьдчилж орсон орлого	1,498,424.82	2,478,833.18	980,408.37
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	7,940,645.30	7,335,757.13	(604,888.17)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>9,744,785.81</b>	<b>10,218,149.39</b>	<b>473,363.58</b>

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 7,741,770.0 мянган төгрөг болж 4,006.3 мянган төгрөгөөр буурсан байна. Оны эцсийн үлдэгдэл нь арилжааны банкин дахь харилцах дансанд 7,741.770.0 мянган төгрөг байршиж байна.

Авлага дансны үлдэгдэл 2,476,379.4 мянган төгрөг болж, 477,369.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 403,559.1 мянган төгрөг болж, 97,843.4 мянган төгрөгөөр өссөн нь сайн дурын даатгуулагчдын урьдчилж төлсөн шимтгэлийн төлбөрийг төсөвтөө багтаан олгосонтой холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,335,757.1 мянган төгрөг болж, 604,888.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сангийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 18,288,985.1 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын төв сангаас 106,052,758.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Увс аймгийн Нийгмийн даатгалын сангийн батлагдсан төсвөөр улсын төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 21,882,741.0 мянган төгрөг, нийгмийн даатгалын төв сангаас санхүүжих эх үүсвэрийг 116,038,043.0 мянган төгрөгөөр баталж, нийт эх үүсвэрийг 13,579,040.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан нь Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 3 дугаар тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлэн тогтоосон, Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 221 дүгээр тогтоолоор тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлж, тэтгэврийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон зэрэгтэй холбоотой байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд нийгмийн даатгалын сангаас гарах 4 сангийн зардал санхүүжүүлэхээр 137,072,423.1 мянган төгрөгийн төсөв батлагдсан. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 136,562,818.4 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/				
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,199.70	5,368.59	1,831.11
2	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	23,733.40	8,733.77	14,999.63
3	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	137,041,490.00	136,548,716.01	492,773.99
	<b>Нийт дүн</b>	<b>137,072,423.10</b>	<b>136,562,818.37</b>	<b>509,604.73</b>

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн данс байхгүй байна.

#### 3.6.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Увс аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Ариунсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 62 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 167,606,420.3 мянган төгрөгийн 1 хувиар буюу 1,676,064.2 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 1,340,851.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 189,407,352.8 мянган төгрөгийн 1 хувиар буюу 1,894,073.5 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 1,515,258.8 мянган төгрөгөөр тогтоосон.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Увс аймгийн Нийгмийн даатгалын сангийн хувьд хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорилыг хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийгмийн даатгалын сан нь тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 157 мэдээллээс хугацаандаа оруулсан 155, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчил илрээгүй болно.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Увс аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмж байхгүй байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарч үзэх чухал асуудал байхгүй гэж үзлээ.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байхгүй												

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Байхгүй												

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Байхгүй								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Байхгүй								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



/М.БАТСУУРЬ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Г.АРИУНСАЙХАН/

2026.03.11